




**“ЛэндМН ББСБ” ХК-ийн
2022 оны хагас жилийн тайлан**



Агуулга

- 2022 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд
- Санхүүгийн үйл ажиллагаа
- Эрсдэлийн удирдлага
- Компанийн засаглал

ЛэндБонд

Дижитал хөрөнгө оруулалт

Дижитал хөрөнгө оруулалт
“ЛэндБонд” хөтөлбөрийн
Транч II-ын хүрээнд 3.1
тэрбум төгрөгийг амжилттай
татан төвлөрүүлээ

3,100,000,000₮

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2022 оны хагас жилийн тайлан

01. 2022 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

Дижитал хөрөнгө оруулалт “ЛэндБонд” хөтөлбөрийн Транч II-ын хүрээнд 3.1 тэрбум төгрөг

2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр арилжаалсан “ЛэндБонд Транч-I”-ийн өгөөж 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр үнэт цаасны дансанд байршлаа.



2021 оны 11-р сарын 29-ний өдөр арилжаалсан
ЛэндБонд Транч-1 Өгөөж
2022.05.31-нд үнэт цаасны дансанд байршлаа

lendmn

Download on the App Store GET IT ON Google Play

Хөрөнгийн зах зээлд 2020 оноос хойш 3 удаа компанийн нээлттэй бондыг гарган нийт 15.6 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлжээ

Санхүүгээ зөв удирдах “Хөрөнгө оруулалт” цэсээр дамжуулан дижитал хөрөнгө оруулалт Лэндбондын захиалгыг LendMN аппликейшнээр амжилттай татан төвлөрүүлээ.



lendmn



Шууд авъя, хувааж төлье

LendMN аппликейшний зээлийн эрхээ ашиглан, хүссэн бүтээгдэхүүн үйлчилгээгээ урьдчилгаа, шимтгэлгүй шууд аваад 60 хоногт 4 хувааж төлөх үйлчилгээ юм.

2 сая хүртэл
Зээлийн эрх

0 урьдчилгаа
шимтгэл
хүү

60 хоногт
4 хувааж төлөөрэй



Төлбөрөө ЛэндМН-ийн зээлийн эрхээрээ урьдчилгаа, шимтгэлгүйгээр шууд аваад, хувааж төлье



Системийн шинэчлэлт, шинэ бүтээгдэхүүнүүд

LendMN аппликейшний бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл нэмэгдэж "Хөрөнгө оруулалт" цэстэй боллоо

"Хөрөнгө оруулалт" цэсний тухай

Харилцагч та бүхэн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн үйлчилгээтэй "Хөрөнгө оруулалт" цэс рүү орж танилцан найдвартай, баталгаатай дижитал хөрөнгө оруулалтын үйлчилгээнүүдээс өөрт тохирохыг сонгон ашиглаарай.

Санхүүгээ зөв удирдъя

Lendplus - Боломжоо нээ

Санхүүгийн хэрэгцээгээ зөвөөр удирдах, мөнгөн хөрөнгөө эрсдэлгүй өөртөө ажиллуулах боломжтой итгэлцлийн үйлчилгээ юм.

Lendbond - Дижитал хөрөнгө оруулалт

Өгөөж өндөртэй, тогтмол хүүгийн орлого хүртэх боломжтой, баталгаатай, захиалахад хялбар, хүссэн үедээ худалдах боломжтой нээлттэй бонд юм.

Lend итгэлцэл - Шинэ боломж

Хөрөнгөө үнэгүйдэхээс хамгаалах санхүүгийн хэрэгсэл болох итгэлцлийн үйлчилгээ юм.

Lendauto Эко автомашины зээлийн үйлчилгээ

LendMN аппликейшнээрээ зээлийн эрхээ тогтоолгоод Эко автомашинууд болох /Toyota Aqua, Prius 30, Prius 40, Prius 41, Sai/ хабрид автомашинуудаа зээлээр авах боломжтой боллоо.

Зээлийн нөхцөл:

- Зээлийн хэмжээ: 20 сая хүртэл
- Урьдчилгаа: 15%
- Хугацаа: 48 сар хүртэл
- Зээлийн хүү: 2.3%-2.6%

(Бид зээлийн хэмжээ үнийн дүнг 30 сая хүртэл нэмэгдүүлэх бонус оноог ашиглах тал дээр судалгаа хийж уян хатан нөхцлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.)

Машинтай болох утас: 7707-0101

Давуу тал:


LendMN аппликейшнээр дамжуулан таны зээлийн эрхийг хурдан шуурхай тогтоох бөгөөд хамгийн богино хугацаанд харилцагчдын зээлийн хүсэлтийг Ажлын 1 өдөрт шийдвэрлэн ажиллаж байна.

lendauto
Эко автомашины зээл

2.3%-2.6%
Хүү

15%-с дээш
Урьдчилгаа

48
Сар хүртэл





Байгальд ээлтэй компани

НОГООН САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИГЧ
ЛэндМН

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулсан “Ногоон санхүүжилт бүс нутгийн чуулган”-д амжилттай оролцлоо.



#дэргэдчиньбайгаа



Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын нэрэмжит “Цэцэрлэгт Хүрээлэн”-ийн шав тавих их үйлсэд нэгдэж, ЛэндМН-ийн хамт олноороо Гачууртын Минж үржүүлгийн газарт мод тарилаа.



ЛэндМН-ийн залуучууд Чингэлтэй дүүргийн Хайрхан Хөгжлийн Төвд 150 ширхэг мод тарилаа.





Хөрөнгийн зах зээлийг дэмжигч ЛэндМН



"IPO Mongolia 2022 Forum"-хүртээмжтэй хөрөнгийн зах зээл форумд
"ЛэндМН ББСБ" ХК ивээн тэтгэгчээр хамтран оролцлоо

Tech
Invest
Powered by HOGOON
2022



"Tech Invest 2022" арга хэмжээ
Оролц, Бүтээлц, Хөрөнгөж



New Work Summit
GOOD WORKPLACE
AWARDS 2022

Ажиллахад таатай ЛэндМН

"Good Workplace Awards 2022" арга хэмжээнд ЛэндМН ивээн тэтгэгчээр хамтран ажиллалаа



"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2022 оны хагас жилийн тайлан

01. 2022 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд



Боловсролыг дэмжигч ЛэндМН

"Глобал Боловсролын Форум 2022"-д хамтран ажиллалаа



lendmn



Онцлох компанит ажлууд



Lendray Шинэ бүтээгдэхүүнээ танилцууллаа "Mongolian Jewellery & Metal Expo-2022" үнэт эдлэл, үнэт металлын үзэсгэлэнд LendMN-ийн шинэ үйлчилгээ Lendray-ээр оролцлоо



Lendзээл-Хэрэглээний зээлийг LendMN-ээс... маркетингийн компанит ажлыг амжилттай явууллаа.



"Авто Машинтай Болоход Амархан" өдөрлөгт Lendauto-Эко автомашины зээлийн үйлчилгээгээр оролцлоо




Зээлийн үйл ажиллагаа


- 2022 оны эхний хагас жилд нийт харилцагч нартаа 127.5 тэрбум төгрөгийн дүнтэй 598 мянган зээлийг LendMN аппликейшнээр дамжуулан олгосон байна. Түүнчлэн 2022 оны эхний хагас жилийн зээлийн голлох үзүүлэлтүүдийг 2021 оны эхний хагас жилтэй харьцуулахад гэрээт харилцагчдын тоо 7.6%, олгосон зээлийн тоо 58.5%, цэвэр зээлийн багц 61.2%-иар тус тус өссөн амжилттайгаар бид 2022 оны эхний хагас жилийг үдлээ.

2022 оны хагас жилийн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал


Нийт зээлийн багц
(тэрбум төгрөг)




Нийт олгосон болон сунгасан зээлийн дүн
(тэрбум төгрөг)




Бүртгэлтэй харилцагчид
(Өссөн дүнгээр, мянган харилцагчид)




Цэвэр зээлийн багц
(тэрбум төгрөг)



Нийт олгосон болон сунгасан зээлийн тоо
(мянган зээл)



Гэрээт харилцагчийн тоо
(Өссөн дүнгээр, мянган харилцагчид)





Харилцагчийн үйл ажиллагаа

Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 20 ажилтантайгаар хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн 2022 оны эхний хагас жилийн турш нийт 307,784 удаагийн зээлийн үйлчилгээ, аппликейшн

ашиглалт болон бусад үйлчилгээний талаар харилцагчдад тухай бүр нь түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж тэдгээрийн 97.73%-д амжилттай үйлчлэн, харилцагчдад тулгарсан асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.

Харилцагчийн үйлчилгээ

2022 оны эхний хагас жилийн хүлээн авсан

258,889

нийт дуудлага

15

 секунд

хүлээлгийн түвшин

Үйлчилгээ

97.7%

амжилттай хүргэсэн

Сошиал суваг болон

48,895

үйлчилгээний заалаар үйлчилсэн





Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд

2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт зээлийн багц 57%-иар өсч 44.5 тэрбум төгрөг хүрсэн ба зээлийн эрсдэлийн сангийн нөөц 3.0 тэрбум төгрөг, чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь өмнөх оны мөн улиралаас 1.06%-иар

буурч 5.98% байгаа нь банк бус санхүүгийн салбарын чанаргүй зээлийн үзүүлэлтээс 1.5 нэгжээр доогуур байгаа ба зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 114.2% хүргэж ажиллалаа.

Тэрбум төгрөг	2021H1	2022H1
Нийт зээлийн багц	28.4	44.5
Зээлийн эрсдэлийн сан	2.7	3.0
Цэвэр зээлийн багц	25.7	41.4
Хэвийн зээл	26.0	40.8
Хугацаа хэтэрсэн зээл	0.4	1.0
Чанаргүй зээл	2.0	2.7
Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь	7.04%	5.98%
Эрсдэлийн сангийн хүрэлцээ	135.0%	114.2%





Санхүүгийн байдлын хураангуй тайлан /Аудитлагдаагүй/

2022 оны эхний хагас жилийн байдлаар компанийн нийт хөрөнгийн хэмжээ 46.40 тэрбум төгрөг байгаагаас цэвэр зээлийн багц 41.44 тэрбум төгрөг, мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 2.02 тэрбум төгрөг байна. Түүнчлэн өртөлбөр 23.16 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 23.23 тэрбум төгрөг байгаагаас хуримтлагдсан ашиг 11.91 тэрбум төгрөг байна.

2022 оны хагас жилийн гол үзүүлэлтүүд

Нийт актив
46.4
тэрбум төгрөг

Нийт орлого
8.1
тэрбум төгрөг

Цэвэр ашиг
1.7
тэрбум төгрөг

Цэвэр зээлийн багц
41.4
тэрбум төгрөг

Санхүүгийн байдлын тайлан

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2021Н1 /Аудитлагдаагүй/	2022Н1 /Аудитлагдаагүй/
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	1.7	2.0
Зээлийн багц (цэвэр)	25.7	41.4
Бусад хөрөнгө	3.7	1.8
Үндсэн хөрөнгө	0.9	0.7
Биет бус хөрөнгө	0.2	0.4
Нийт хөрөнгө	32.2	46.4

Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/	2021Н1 /Аудитлагдаагүй/	2022Н1 /Аудитлагдаагүй/
Өр төлбөр	14.0	23.2
Эх үүсвэр	12.5	20.4
Бусад өглөг	1.5	2.8
Эздийн өмчийн дүн	18.2	23.2
Хувьцаат капитал	9.1	8.5
Хоёрдогч өглөг	-	2.8
Хуримтлагдсан ашиг	9.1	11.9
Нийт өр төлбөр болон эздийн өмч	32.2	46.4


Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Аудитлагдаагүй/

2022 оны эхний хагас жилийн байдлаар компанийн нийт орлогын хэмжээ 8.1 тэрбум төгрөг, цэвэр ашиг 1.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /тэрбум төгрөг/	2021H1	2022H1
Нийт орлого	6.4	8.1
Хүүгийн зардал	(1.7)	(1.8)
Цэвэр орлого	4.7	6.3
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	0.3	(0.8)
Үйл ажиллагааны цэвэр орлого	5.0	5.5
Удирдлагын болон ҮА-ны зардал	(2.9)	(3.6)
Татварын өмнөх ашиг	2.1	1.9
Татварын зардал	(0.3)	(0.2)
Цэвэр ашиг	1.8	1.7

02. Санхүүгийн үйл ажиллагаа

Шимтгэлийн орлого (тэрбум төгрөг)



Цэвэр ашиг өссөн дүнгээр (тэрбум төгрөг)






"ЛэндМН ББСБ" ХК

1.1 тэрбум төгрөгийн НОГДОЛ АШИГ

хуваариллаа

"ЛэндМН ББСБ" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 2 сарын 7-ны өдрийн 22/03 тогтоолоор Компанийн 2021 оны цэвэр ашгийн 27.5%, нэгж хувьцаанд 1.50 төгрөг буюу нийт 1,108,952,525.50 төгрөгийн ногдол ашгийг олгохоор шийдвэрлэсний дагуу "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК-аар дамжуулан 5,473 хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд ногдол ашгийг байршууллаа.

Хувьцааны ханшын мэдээлэл




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2022 оны эхний хагас жилд компанийн нийт 4.59 сая ширхэг хувьцааны арилжаа хийгдэж компанийн нэгж хувьцааны ханш 34.99 төгрөгөөр хаагдлаа.

2022 оны эхний хагас жилд:

Нийт арилжаалагдсан ширхэг - 4.59 сая ширхэг
Нийт арилжаалагдсан үнийн дүн - 188.38 сая төгрөг

Хувьцаа
эзэмшигчдийн
эзлэх хувь





Эрсдэлийн удирдлага

"ЛэндМН ББСБ" ХК Эрсдэлийн удирдлагын гурван шатлалт хамгаалалтын бүсийг хэрэгжүүлэн ажилладаг.

2022 онд зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, мэдэгдэл, хууль, журмын шинэчлэлийг цаг алдалгүй өөрийн үйл ажиллагаанд нийцүүлэн мөрдөн ажиллаж байгаа төдийгүй харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон компанид ирээдүйд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй нэгдсэн тогтолцоог бүрдүүлж ажилласаар байна. 2022 оноос салбарын болон нийтээр

дагаж мөрдөх хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор өөрийн үйл ажиллагаандаа нийцүүлж холбогдох журамдаа орууллаа.

Үүнд:

- Хөдөлмөрийн дотоод журам
- НББ баримт бичиг
- Зээлийн үйл ажиллагааны журам
- Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам болон хөтөлбөр
- Нууцлалын журам

Хагас жил тутамд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний

тайланг СЗХ-руу хүргүүлээ.

ЛэндМН ББСБ" ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-д заасны дагуу 2022 оны хагас жилийн байдлаар 1.63 тэрбум


төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 3.03 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 114.2%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2021Н1	2022Н1
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	50.0%	41.5%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	50.0%	47.3%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	56.6%	43.9%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	12.3%	8.7%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	-14.9%	-10.0%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	36.8%	37.1%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	6.4%	44.5%



ЛэндМН ББСБ"ХК-ийн бүтэц






Компанийн засаглал

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал



“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Компанийн ТУЗ-өөс гаргасан товын дагуу 2022 оны 3 дугаар сарын 26-ны өдөр цахимаар амжилттай хуралдлаа. Тус хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.28%-тай тэнцэх хувьцаа эзэмшигчид оролцсон ба хурлаас дараах шийдвэрийг гаргасан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 оны хагас жилд ээлжит 3, ээлжит бус 2 удаа хуралдав.

Компани нь 2022 оны хагас жилд ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг дор дурдсан байдлаар хэрэгжүүлэн ажиллаж байна:

Хэрэгжсэн: 18
Хэрэгжиж байгаа: 3
Хүлээгдэж байгаа: 0

Компани нь 2022 оны хагас жилд ТУЗ-өөс гаргасан шийдвэрүүдээс 18 шийдвэрийг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд Бизнес, стратеги болон эх үүсвэртэй холбогдуулан гаргасан нийт 3 шийдвэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод



“ЛэндМН ББСБ” ХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх гурван хороодтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

- Туз-ийн дэргэдэх засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо
- Туз-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо
- Туз-ийн дэргэдэх аудитын хороо



THANK YOU